

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Дашийн Батгомбо	Дугаар	L109
Оршин суугаа аймаг	Хэнтий	Оршин суугаа сум	Өмнөдэлгэр
Төрсөн газар	Өмнөдэлгэр сум	Төрсөн он	1918
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Балданбарэйвүн, Хүүхэн хутагтын хүрээ, Мандалын хүрээ, Хангалын хурал, Баруун Жаргалантын суварга, Хөгнийн шүтээн, Саригийн хурал	Сүм хийдийн дугаар	ХЭРД077, ХЭРД073, ХЭРД071, ХЭРД074, ХЭРД076, ХЭРД 081, ХЭРД 070
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 7-р сарын 3	Ярилцлага авсан хүн	Ж.Одгарьд



Хэнтий аймгийн Балдан Барэйвүн, Хүүхэн хутагтын хүрээ, Мандалын хүрээ, Хангалын хурал, Баруун
Жаргалантын суварга, Хөгнийн шүтээн, Саригийн хурлын тухай

-Та 9 настай Барэйвүнд сууж эхэлсэн юмуу?

Тиймээ. 9-16 хүртэл суугаад Барэйвүн маань татан буугдаад би энд хар болсон юм даа. Хар болоод сургууль соёлд явсан.

-Та Барэйвүнгийн тухай яриач? Хэдэн онд байгуулагдсан?

Чухам хэзээ байгуулагдсаныг нь мартчихаад мэдэхээ болиод байна. Гол нь бол Цогчэн дуган нь гурван давхар дээрээ гол нь их сахиус гэж байсан юм. 6 лам хурдаг тийм сахиус байсан. Тэрэнд би одоо нэг жил завъяа гэж одоо манз цавыг барьдаг ажил хийсэн. Дотроо 2 хүрэн зандан хэнгэрэг байдаг байсан. Орохоор л их сэнгэнэсэн

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

үнэр ханхалаад байдаг байсан. Нэг их сийлбэртэй, сийлбэр нь дан луу ороосон хүрэн өнгөтэй тийм хэнгэрэг байсан. Голын их дуган Цогчэн дуган гэж одоо ердөө бага сургууль юм л даа. Тэнд бол дохио мохио бүх зүйлийг тэндээсээ анхан үүсгэж гардаг байсан. Өглөөдөө цогчэн гэж хүүхдүүд бол 8 цагийн багцаанд цуглаад 10, 11 цагийн алдад тарж байгаа юм. Онцгой том хурал биш болохоор Цогчэнг өдөртөө ганц хурдаг байсан.

- Барэйвүн хийд маань хурлын хэдэн дугантай байсан бэ?

Дуган бол нэлээн хэд байсан. Хамгийн гол нь Цогчэн их дуган. Хойд мухарт шарил Барэйвүн гэж байсан. Шар дуган байсан юм. Тэрний зүүн талд Тонжийн дуган гэж одоо суварга ч юмуу даа нэг тийм цагаан сүм байсан. Шар дуганы түүх нь гэвэл Шар дуганы суурин дээр нэг хэдэн ямаатай нэг өвгөн хөгшин хоёр дээр үед Барэйвүн үүсээгүй байхад тэнд байж байсан юм гэнэ лээ. Тэгээд өвгөнийг Балдан гэдэг байсан. Хөгшний нэрийг Бэрээвэн гэдэг байсан гэнэ лээ. Тэгээд тэр хоёр хөгшний нэрээр Балдан Бэрээвэн гэж нэрлэгдсэн гэнэ лээ дээ. Тийм бүр ар хаяанд модны захад байгаа даа. Хоёр Чойртой байсан юм. Баруун зүүн хоёр Чойр байсан юм. 4 аймаг байсан юм. 4 аймгийн зүүн урд талд нь Чойнхор аймаг гэж байсан. Баруун урд талд нь Намжаа (Тойслан байх) гэж байсан юм. Баруун хойд талд нь Тэгчилэн гэж байсан юм. Зүүн хойд талд нь Намжаа гэж байсан. Ийм 4 аймаг байсан юм. Чойнхор аймгийн хойд талд Зурхай гэж байсан. Дан тоо, байгаль тийм юм хийдэг байсан. Газрын сайн мууг сайн олдог тийм л газар байсан. Тэрэнд хэрийн хүн суудаггүй байсан. Манайхны нэг ах лам тэнд суудаг байсан. Тэгээд намайг тэнд сууж чадахгүй ээ. Тархи нь хүрэхгүй гэдэг байсан. Тэр үед нэлээн шаггүй хүн л суудаг байсан. Тэр чинь шалгалт шүүлэг гэж жилдээ нэг авч байгаа юм. Нэг модон тагш аяганд шар будаа хийгээд тэгээд тэрний тооцоог гаргаж чадах чадвараар авдаг байсан. Тэрнийг мань мэтийн юм яаж ялгахав. Цэцэг гайманг ингэж тойруулж зураад тэгээд тэрэн дотор нь хэмжүүлдэг тэгээд тэрэн дотроо бүх модны тооцоогоор шалгалт авдаг, ер нь их нарийн шалгалт авдаг байсан. Тэрнийг давж гарсан хүн л Да зурхайч болдог байсан. Тэр бол маш ховорхон байдаг байсан. Миний мэдэхийн хоёр гуравхан өвгөн байдаг байсан. Тэгээд хоёр хувилгааных байсан.

-Тэр хоёр нь бас хурлынх юм уу?

Нэг нь Гомбожавын Найдансүрэн гээд Номун хаан хувилгаан гэж байсан. Нэг нь Цэдэнпунцагийн Гомбожагдан гэж жижигхэн хувилгаан байсан. Номун хаан гэдэг нь маш хэрцгийн танхай тийм хувилгаан байсан. Их ч баян хүний хүүхэд байсан. Тойн лам гэдэг нь ядуу хүний хүүхэд байсан. Гэхдээ их тарган цатгалан байсан. 32-той залуухан байхдаа хэлмэгдсэн. Номун хаан нь 50 дөхөж байсан даа. Баруунхараагийн лагерт байж байгаад нас барсан байхаа. Маршал Чойбалсангийн багш нь байсан юм гэнэ лээ. Тэгээд энэ Хэнтий аймагт мөрдөгдөж байхад нь хот руу аваачаад Баруунхараад аваачаад тэнд 10 жил эдлүүлээд тэгээд энгийн болгож байгаад Хараад нас барсан юм гэнэ лээ. Өөр жүд гэж байсан. Жүд бол шашны дээд сургууль шүү дээ. Аграмба гэдэг Жүдээс болсон юм, гавж гэдэг Чойроос болсон юм. Шашны яам гэж байсан. Энд одоо арван хэдэн том гэртэй. Би тэнд мөн л цав манзыг нь зөөдөг байсан. Дандаа мөнгөн завъяа, мөнгөн савх хэрэглэдэг байсан. Тэнд гурван бичээч суудаг. Хурал бол одоо чуулгаас (илүү) ердөө тасрахгүй. Их маргалдана. Тэнд бол хүнийг муушах талаас ч ярина, сайшаах талаас ч ярина. Хийдээс хөөх үгүй талаар ярина. Зарим нь тийм гэнэ, зарим нь үгүй

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

гэнэ. Ингээд баахан маргалддаг байсан. Тэр гавж, аграмба гэдгийг м гэдгийг дандаа тушаалаар буулгадаг юм. Тэр чинь хүн сайн дураараа биш шүү дээ.

-Дамжаа барьж байж дом тавина биз дээ?

Тийм. Тэр бол боллоцоотой нэлээд баян хүнийг гавж болгож тушаа гэнэ. Гавж болно, аграмба болно. Тэр хөөрхий өмсөх хувцас, юу ч байхгүй. Тэгээд яахав нэг жилийн хугацаатай бадар бариулж айлаар явах зөвшөөрөл өгдөг. Тэгээд шашны яамны зарлиг гэж ярьдаг. Тэгээд нэгэнт л зарлиг гарсан бол ядуу ч хамаагүй хошуу дамжаад л явна даа. Манай Аюуш гэж 2 хувилгааных одоо хурал номын газар ихтэй, өөрсдөө ч байртай склад бүх юм нь бүрэн байсан.

-Өөр юуны дуган байсан бэ?

Өөр Мамба гэж байсан. Одоо эрүүлийг хамгаалах л газар л даа. Зайсан, Лавиран гэж хурлууд байсан. Тэр бол отог овог гээд тэрүүгээрээ ялгагддаг юм байна лээ. Дүйнхор гэж нэг хурал байсан. Тэр бол маш нарийн, хүүхэд орж ажилладаггүй, томчууд ажилладаг маш гоё газар байсан. Үүд энэ тэрээ онгойлгодоггүй, маш нууц байсан. Хувцас хунар бол голдуу хөх, хүрэн эдлэл эдэлдэг байсан. Тэр гэсгүй гэж байгаа энэ тэр нөмөрсөн жанч энэ тэр шар өнгөтэй том дугуй янз бүрийн тийм юмнуудтай. Тэр малгай бүч энэ тэр нь хөх, хар хөх байсан. Хурал хурж байхад хаалга хаалттай тэгээд орой дээрээ нэг хонхтой тэгээд есөн ширхэг унжуургатай байсан. Тэгээд үүдэндээ бүрээ бишгүүртэй. Үүдний завсараар харахаар нэг их олон зулын гэрэл харагдахаас биш яриа нэг их сонсогдохгүй. Том л лам нар хурдаг байсан.

-Дүйнхорын зарлигнаас хурдаг байсан уу?

Тэр одоогоор бол Дотоод яамархуу газар юм уу.

-Дүйнхор дацандаа Дүйнхорын л ном хурах байх л даа.

Бадма Ёга гэдэг газар бас хурдаг байсан. Тэрэнд бас л том үлсүүд хурдаг байсан. Ямар сайндаа манай энэ Баян-Адаргын нэг өвгөн ярьсан байсан. Нэг залуу лам хаана хурвал дээр вэ? Хаана ашигтай вэ гэж тэр ламаас асуусан байна. Намсрай гэдэг өвгөн л ингэж хэлсэн байсан. Хүүр дагая гэвэл зурхайд хураарай, хүнээ байя гэвэл Бадамын ёгат хураарай, хэл амтай больё гэвэл Чойрт хураарай гэсэн байсан. Хэл ам, хэрүүл шуугианд дуртай бол Чойрт хураарай гэсэн гэдэг. Хүн алья гэвэл Манбад ороорой гэсэн гэдэг. Тэр нь сүүлдээ ном болоод бичигдсэн гэдэг. Пүрэвдорж гэдэг хүн бичсэн байсан.

Зүүн урд талаараа Манзушир хэдэн бурханаар хашигдсан гэдэг юм. Урд талдаа Очирваань гэж бурхан байдаг юм. Баруун хамар дээрээ Жамсран гэж нэг бурхан байдаг юм. Таван хаан гэж. Таван хаанд нь бол одоо голдуу миний л мэдэхийн Чойжин байдаг байсан.

-Тэр тойрсон дандаа сүмүүд байсан уу?

Дандаа сүмүүд байсан. Өнөө ч тэр Жамсрангийн гээд жижигхэн сүм босгосон байв уу. Тэгээд хойноо Шарил Барэйвүн. Зүүн хойд хамар дээрээ Дамдин чойжоо гэж байсан. Тэр хаданд соёмботой гурван давхар Майдар бурхан гэж байсан. Майдарын хурлын дэргэд нүгнээ гэж зүгээр модон байшин байсан. Тэрнийг Цэнхэр рүү Гомбодорж гэдэг хүн Согтуугийн хийд гэж энэ Цэнхэрт Даянтад нэг хийд байсан. Согтуугийн хийд гэдэг нь дан

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

архи хэрэглэдэг. Бурхан тахилдаа ч архин тахил тавьдаг, лам нар нь дандаа согтуу байдаг. Тэр лүү нүүлгээд аваад явчихсан юм. Тэгээд тэрнээс урагшаа Хүүхдийн сүм гэж хүн ч хурж байгаагүй, хүүхэд л баахан тоглож байдаг нэг тийм сүм байсан юм. Одоо тэнд сүм нь ч байхгүй, бурхныг нь сэргээгээд будчихсан л байна лээ. Алтан маани байдаг юм. Тэгээд жасууд байдаг юм. Жас маань одоо аж ахуйн газар байдаг шүү дээ. Их буух гэж тэр Их сумын баруун талд хэдэн их зэс тогоотой дотор нь одоо гарсныг нь цэвэрлэж байхдаа нэг төмөр хүртэй, 4 метрийг банз хаяад дөрөвхөн хүн ажиллана. Ямар ч тэргээр дүүрэн гурилтай махан цав ч ирсэн тэр зүгээр л жирийн хоол шиг сайхан буулгаад авна.

Хоёр цаг болоод л цай хоолонд ордог, дөрөвхөн хүн ердөө саадгүй өдөр шөнөгүй ажиллана. Өвлийн цагт бол нэг тогоонд нь 10 тэрэг мөс орчихно. Тэгээд тэр 4 хүн ердөө шөнө ч унтахгүй, өдөр ч байж л байна. Тэгээд дээрээ нэг саравчтай туурга байхгүй ханатай, тэгээд хар тостой хөвөнтэй дээлүүдтэй ажилладаг байсан.

Тантан хийд гэж суварга дээр Лхам гандайн цам энэ тэр гэж гараад л баруун хойд 2 км хэрээтэй газар байсан. Тэнд Гомбо гавж гэдэг хүн тэнд нэг хийд босгосон юм. Нуванхорол гэж эмэгтэй хөгшин хоёр. Тэр Ловон хорол гэдэг нь дан эмэгтэйчүүдээр чулуугаар сүм бариулаад тэндээ тэгээд бүх юмаа хийсэн байсан даа.

-Та Тамтангийнхаа хурлын талаар яриач?

Сахиус нь Балган шавш сахиустай. Юлхэ гэдэг нь нэг сахиус байгаа юм аа. Тэр нь Улаан сахиусны салбар юм билээ. Лхам Аригжигмаа гэж бий. Энэ бол өрөөсөн хөхтэй, ганц шүдтэй, хоёр нүд байхгүй сохор тийм бурхан гарч байсан. Тэр бол Лхамын талын бурхан гэнэ лээ. Найман мам гэж гарч байсан. Тэр нь пад хар царайтай, хөх нүдтэй, нэг их том модон хөхнүүдтэй, үнс авч байгаад л цацдаг, тэрнээс сэжиглэнэ гэж жигтэйхэн, зугтаацгаадаг байсан.

-Тийрэнгийн нэг л дүр гарах уу?

Тийрэнгийн ломбай гэж гарч байгаа. Тэр нь толгой дээрээ нэг далбаатай гозгор юу өмсчөөд, дугуй мод гартаа эргүүлээд газар унагаахгүй хойшоо урагшаа 3,3 ухарч гүйгээд тэгээд цам нь тэр дээ. Тэгээд эргүүлдэг модоо бариад зогсч байна. Нийтэд нь бүх цамаа Лхам гандайн цам гэдэг. Энэ Хутагтынхаас л эх авч сүүлд байгуулагдсан юм гэнэ лээ.

-Тамтангийн хурал хэдэн онд байгуулагдсан юм бол?

1934,35 оны үед байгуулагдсан. Удаагүй тэгээд 3 жил гаран болоод татан буугдсан.

-Дандаа аниа нар хурдаг байсан гэсэн үү?

Тийм.

-Бэрээвэнгийн урд руу Тамтанжалба гэдгийн тэнд дандаа лам нартайгаа хольж хурдаг зоч нар байсан уу?

Энэ урдхан Тойн овог гэж зоч нарын хийд байсан. Эмэгтэй улсууд тэнд зүгээр ван шагналыг нь авахаас биш хуралд нь суудаггүй байсан. Тэр нь Тойн овгийн хурал. Тэр лам нарын Бэрайвүн хийдийг дээр үед байгуулсан хийд байсан юм гэсэн.

-Тэр Тойн овгийн хурлаа Тамтанжалба гэж нэрлэж байсан уу?

Үгүй. Тантан гэдэг нь тусдаа баруун хойно байсан юмаа.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

-Тойн овгийн хурал Бэрэйвүнгийнхээ хүрэн дотор хамаарах уу?

Тийм. Тэгээд л одоогоор Тэд өөрийн зиндааны улсуудын заримыг урьдаг гэсэн ирээч гэж. Тэгээд тэд нь уулын аманд галзуурч байгаа юманд хэнд очдог юм гээд тэд нар нь очдоггүй энэ тэр байсан гэсэн. Уулын аманд нэг хийд байгуулчихаад ханхай байшинд хэдэн зураг тавьчихаад хүний чөмөг үлээж, хөндий мод нүдээд байгаа юманд хэн очдог юм гэж байна гэж хэлээрэй гэдэг байж. Хүмүүс тэгэхээр нь хэлж чаддаггүй байсан гэнэ лээ.

-Тойн овгийнх нь Барэйвүнгээсээ хүмүүсийг гэдэг байсан юмуу ?

Үгүй. Тамтангийнхан нь Тойн овгийнхныгоо ир гэдэг байсан юм. Тойн овгийнхон Барэйвүнгийн харъяа газар байхгүй юу. Тамтан хийд бол эрэгтэй эмэгтэй хоёр хүний байгуулсан хувийн л хийд. Нуванхорол гэж нэг хөгшин байж байгаад 1959 онд энэ хойд Хэнтийд нас барсан.

-Туваанжав гэж хөгшин байсан гэсэн?

Тэр чинь бол бага унзад гэж байсан хүн. Тамтангийн хийдийн хүн. Барэйвүнгийн Тойн отогт бол ван жамъянг нь хүртсэнээс бус хуралд нь суудаггүй тийм хүн байсан юм. Тэр чинь бол жорзонд 108 хоног явдаг. Тэгээд уртын жорз гээд 3 жилийн хугацаатай явсан хүн байхгүй юу. 2 жил нь яваад 1 жил нь лам нар нь татлаганд орчихлоор зэрэг тэр Нуван хорол гэдэг хөгшин багш нь байсан юм байна лээ л дээ. Тэр очиж уулзаж гэнэ л дээ. Тэгээд хэлж гэнэ. Чамаас байтугай нь ингээд байхгүй боллоо. Барэйвүн хийд байхгүй боллоо. Чи одоо дуусгах нь ч яахав 1 жил гаран дутуу л юм байна. Гэхдээ одоо дуусгасан нь дээр. Тэгээд дууссан гэдэг. Сүүлд хүн амьтан орж ирэхлээр үнэр танар гэж андашгүй болсон гэдэг. Одоо зэрлэгших гэж байна гэж. Улаан дээл нь зэвхий цайгаад ирсэн гэсэн шүү. Би тэр Далтад байхыг нь мэднэ. Тэнд нэг хүн хаячихсан байсан. Нэг цагаан даавуугаар ороогоод. Тэгсэн чинь жодгор гэдэг шовгор юм барьчихаад яг толгойн тэнд 7 хоног байсан. Хүн тэр хүүрэн дээр юу аваачиж өгөх вэ дээ. Юу ч өгөхгүй байгаа юм. Улсууд тэр Далтын энгэр гэдэг уулан дээрээс харчихаад Туваанжав одоо давгүй л байдаг юм байх даа. Тэгсэн тэр маань сүүлд жирийн болсон үедээ ярьж байсан л даа. Таныг тэгээд байж байхад уулан дээрээс харж байсан гэхэд өө бумбатай рашаанаасаа нэг жаахан хэлэндээ хүргэчихээд л байхад давгүй шүү дээ. Би хойно Дэлгэрхаан ууланд цөлд бараг нэг жилээ ихэнхийг нь шахуу авсан шүү дээ гэсэн. Цэвэр ус амсаад л тэгээд л болоо, давгүй байдаг юмаа гэсэн. Тэр бол яахав, анхан өргөсөн тангараг байна тангарагаа биелүүлэх ёстой юмаа гэсэн.

-Та түрүүн хэлсэн Майдарын сүм гэж тусдаа сүм байсан уу?

Тийм. Майдарын сүм гэдэг чинь энд талд хаданд нь гурван давхар байгаа даа. Хойд талдаа сийлсэн соёмботой.

-Яг тэрний тэнд Майдарын сүм гэж байсан юмуу?

Тэрний урд гурван давхарт Майдар бурханы сүм, Майдарын хурал хурдаг газар байсан.

-Тэр нь тусдаа бүр Майдараас өөр юм хурахгүй сүм үү?

Майдар гэдэг маань хаданд сийлэгдсэн бурхан байсан. Тэгээд нөгөө бариа тавианы үеэр чинь цохиж нүдээд заримыг нь дийлэхгүй болохоороо хөө түрхээд.

-Ламрим дуган гэж байсан уу?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ламрим гэж байсан.

-Ганжуурын дуган гэж байсан уу?

Ганжуурын дуган гэж яахав, Их дуганын араар олон хүрд юунууд байсан л даа. Жинхэнэ Ганжуур маань Их сүмдээ байдаг байсан.

-Өөр шүтээн залсан тойрсон сүм, суварганууд байсан уу?

Өөр ч одоо сүм суварганууд юу билээ, бүр дээр үед их олон лам нартай байдаг байхдаа зүүнтшээ Их хүрээ гэж байсан юм гэнэ лээ. Сүүлдээ хамтрал коммуны үеэс эхлээд бага болгосон юм гэнэ лээ. Очирдарийнх гэдэг айл (дуган) байсан. Аль томчуудыг хүлээж авдаг газар байсан. Тэр том дуганы үрд байсан. Нэг их сийлбэртэй замгүй их гоё оо. Гадуураа шар будгаар будсан зандан хашаатай, тоосгон шалтай, том модон гэрүүдтэй, энэ тэр одоо аль чухал томчуудыг хүлээж авдаг байсан. Тэр бол дээхэн үед, хамтрал коммуны үед устсан юмаа. Тэр үед лам нарын лам нарын мөнгө, хийдийн мөнгө гэж хамаагүй их гардаг болоод тэрэндээ тэрийгээ буулгаж худалдсан юм.

Иймэрхүү л юм байсан юм. Цам гардаг урлагын газар гэвэл Голын овгор гэж дунд нь гэдэг ийм олон тойрсон арзгар шургуу хайстай тийм талбай байсан юм. Цамын сүм гэдэг нь одоо орон дээр нь багасгаад Бэрайвүнгийн хурлын байр барьчихсан байна лээ. Хангалын сүм гэж хойшоо байсан юм. Том сүм байсан юм. Тэрэнд цамын хэрэглэл байдаг. Тэр үед цамын хувцас хунар гэвэл Монгол оронд хамгийн гоё байсан гэж яригдаж байсан юм гэнэ лээ. Зөвхөн улаан сахиусны баг гэдэг нь дан шүрэн багтай байсан гэдэг. Шүрэн багийг жаран жингийн хэмжээтэй юм гэсэн. Тэрийг Чойдонгийн Цэдэндорж гэдэг хүн өмсөж догшин цамд тоглодог байсан юм. Тэр шүрэн багтай жаахан Дүрсий Аажав гэдэг хүн гараад мөрөө мулталчихсан юм. Дараа нь тарган Гонгор гэдэг хүн гараад хүзүүгээ гэмтээгээд тэгээд сүүлд цаасан баг л хэрэглэхээс биш шүрэн багийг анхандаа л нэг өмсч гараад тайлчихдаг байсан. Их дуганы үрд довжоон дээр хоёр их баатарын баримал байдаг байсан юм. Баруун талынх нь Бүүвэй баатарынх, зүүн талынх нь Шижир баатар гэдгийн баримал байсан. Жалчин ший гэдэг нэртэй тийм хоёр жижигхэн одоо энэ айлын жижиг амбаар шиг мухар цагаан хоёр жижиг саванд байдаг байсан. Томоохон хурлууд дээр хааяа нэг онгойлгож салхи оруулдаг байсан.

- Бэрайвүнгийн цамд бүх дүр гарч байсан гэж байгаа биз?

Бэрайвүнгийн цам гэдэг бол их том сайхан цам байсан. Их ч холоос хүн ирдэг байсан. Бэрайвүнгийн Майдар нь ч их том, улаан тэрэгтэй байсан. Майдарын ногоон морь нь ч их гоё зүстэй байдаг байсан. Жинхэнэ Майдарын морь гэдэг нь их гоё эмээл хазаартай сайхан шарга морь хөтлөөд гардаг байсан. Бэрайвүнг чинь одоо дээр үед бидэнд ярьж байхдаа манай Бэрайвүн шашны хоёрдугаар нийслэл шүү дээ гэж ярьдаг байсан.

- Бэрайвүнгийн цамын талаар тодруулахгүй юу? Хэд дэх өдөр гардаг байсан юм?

Бэрайвүнгийн цамын хамгийн чухал томууд нь Чойжоо, улаан сахиус, 21 дарь эх гэж Шанаг гэж 21 шанагийн хувцастай голдуу л хөгшивтөрхөн лам нар ихэвчлэн гардаг байсан. 2 баатар одоо Бүүвэй баатар, Шижир баатар хоёр ч сороо хамгаалахаар гарна. Тэрэнд бол хөдөөнөөс харцуул голдуу ирж гардаг байсан. Харцуул гардаг дүр бол 2 баатар, Гомбын хэрээ. Хоёр арслан гарна. Хоёр арсланг 2 хар хүн хөтөлнө. Тэгж байсан юм.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Хэрээнд гарах хүнийг цамын урд өдөр орой сайхан бүрүй болохоор цамын янсан гэж бүрээ бишгүүр хангинаад явчихна. Тэр бол өглөөний нар гартал хангинана. Тэгээд үүр цайтал хангинадаг байсан. Нар шингэхээс эхлээд. Тэгэхээр хэрээнд гарах улсууд ирээд орой цав, манз идэж уух юманд орчихоод толгойнхоо багийг өмсөлгүй зөвхөн хэрээнийхээ бусад хувцасыг өмсөөд хойд ууланд гарна даа. Тэгээд тэр уулын халзан дээр, овооны урд гарч унтана. Өглөө үүр тэмдэгрэх үеэр дэгдэж гүйж орж ирнэ. Тэр хэвээрээ явж байгаад хурлынхаа дуганд ороод юм идэж уугаад багаа өмсөөд гарна даа. Баатарт гарах улсууд хамгаалаад л гарна даа.

Гомбын хэрээнээс өөр хэрээ гарах уу?

Үгүй.

-Өөр Гомбын хороос юу гардаг байсан юм бэ? Хэрээнээс өөр.

Хэрээнээс өөр юм гарахгүй ээ.

-Барэйвүнгийн сүм дацангууд тус тусынх нь лам нар хэр их олон лам нар хурж байсан талаар санаж байна уу?

Ном үзээд. Жилдээ нэг шүүлэг авна даа. Муу байвал ахиад авна. Шүүлгэнд оролцсоны шанд нэг жаахан бөөрөнхий шар тос, нэг жаахан бөөрөнхий цагаан тос, нэг хавсайны булан, дөрвөн ёотон өгдөг байсан.

-Та өөрөө яг аль дацанд нь голлон хурж байсан юм?

Би Чойнхор аймагт хурж байсан. Хоёр Чойрт хурж байсан. Баруун зүүн чойрт.

-Та Чойрт аль зиндаа хүртэл явсан бэ?

Зүүн Чойрт би хоёр дахь зиндаандаа явж байсан. Баруун чойрт дом тавих домын дамжаанд хүрчихсэн байсан. Тэгээд дом өнгөрсөн хойно ирээд, тэгээд тэр намраас чойрууд татан буугдсан. Би Эрэнцав орж ирчихээд домоос хоцорчихсон юм.

-Таны зиндаанд хэдэн хүн байсан бэ?

10 гаран 20 шахуу хүн байсан. Одоо бүгд нас барж гүйцээд ганц нь одоо баруунтай байдаг сурагтай байсан.

-Хэн гэдэг хүн байна вэ?

Гунгаадулам гэдэг өвгөн байгаа. Лам байсан юм. Тэр маань уг нь надаас хэд дүү.

-Бусад дацангуудын талаар?

Анхан намайг 9 настай ороход Цэнд гэдэг хүнд, Барэйвүнгийн том цорж ламд шавь оруулахаар сахил уншуулсан. Тэгэхэд надад гурван цагаан толгой хэлж өгсөн. Энэ гурвыг тэгээд үзэж сураарай гэсэн. Би нэг ах ламтайгаа хүрээнд суухаар байсан юм. Одоо лам боллоо гээд нэрийг маань сахилын нэр гэж нэг сольж өгөөд тэгээд долоо долоон үсэг гурван цагаан толгойноос хэлж өглөө. Энэ гурвыг л үзвэл чамд аль нь ч эрдэм болно. Гурвууланг нь үзээрэй гэсэн. Төвдийн цагаан толгойноос 7 үсэг хэлүүлээ. Монгол цагаан толгойноос 7 үсэг, латинаас 7 үсэг зааж өглөө. За тэгээд энэ гурван цагаан толгойг гурвууланг нь сурахад чамд хэрэгтэй шүү гэсэн. Энд одоо Номун хааныд латин хичээл долоо хоногийн бямба гарагт бараг хоёр цаг хийж байгаа. Энэнд саадгүй очиж сууж байгаарай гэсэн. Монгол бичиг зүүн хажууд Пүрэв гэдэг хүн зааж байгаа юм. Тэнд очиж заалгаарай. Төвд номыг ч яахав өөрийн ах ламаар заалгана биз гэж хэлсэн. Тэгээд сүүлдээ латин ч байхгүй юу ч байхгүй. Латин ч яахав долоо хоногт нэг 2 цаг ордог юм. Тэгээд гадуур эрхэлж, хүүхэдтэй гадуур ноцолдоод

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно.

© Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

өнөө 2 цагийг нь тасдаад л өнгөрчихдөг байсан. Уг нь үзсэн бол хэрэгтэй л байсан байна лээ. Тэр Бармид цорж гэдэг бол Барэйвүнгийн хамгийн том хүн, хамба нь байсан. Тэр бол анхандаа ном мэддэггүй хүн байсан гэсэн. Юу ч мэддэггүй хүн байж байгаад Барэйвүнгийн зарлага, дуганч хийж эхэлсэн юм гэнэ лээ. Тэгээд сүүлдээ нэг хайнагийн шартай ус зөөдөг байж байгаад сүүлдээ галч тогооч болоод тэгээд нярав болоод хүнсний нярав болоод. Тэгж байхдаа ном энэ тэр үзэж л байсан юм байх. Тэгээд сүүлдээ номондоо сайжраад Барэйвүнгийн оронгийн хамгийн том гавж болсон гэсэн. Анхандаа ном мэддэггүй байж байгаад сүүлдээ уншлага ч ихтэй болж хэдэн зуун шавьтай болсон юм гэдэг. Сүүлдээ өөрөө өвгөрөөд болих гэж хүсэлт оруулаад Дармын Бор гэдэг хүнийг орондоо болгосон гэдэг. Тэрнийг улсууд зайлуул хөөрхий ном мэдэхгүй юм болголоо. Баян хүнийг зусардлаа. Баян болохоор нь цорж болголоо гээд их хэл амтай байсан гэдэг.

-Та хурж байсан үеийнхээ хийдийн Цогчэн ламаас авахуулаад шунлайв, лам гэсгүй нарыг хэлж өгөөч?

Барэйвүнгийн цорж бол байсан юм. Дараагийнх нь Дармын Бор гэдэг хүн байсан юм. Тэрний доод талын Да лам нь Огторын Гомбо нөгөө нь бас нэг Гомбо байсан юм. Цогчэн их унзад байсан юм. Тэр нь бол Дагдангийн Сэдэд унзад гэж хүн байсан. Тэрний дараа Цэндэг гэдэг хүн байсан. Тэр татлаганд явуугаа явсан жилээ хамгийн түрүүнд шахуу таслуулсан. Гарсны дараа ердөө удалгүй жил гаруйхны дараа Налайхын Хорихын дарга болчихсон байсан. Моёор цолтой болчихсон байсан. Тэгээд энд ирээд манай энэ баруун хороололд 1980 хэдэн онд нас барсан даа. Нэлээн л үнэтэй цээтэй хүн болсон байгаа биз дээ. Улсаас баахан хөнгөн тэрэг энэ тэр том том дарга нар ирж ажлыг нь өнгөрөөлөө гэсэн. Сүүлд нь Тарган Гонгор гэдэг хүн байсан. Одоо энэ жил суваргыг нь босгох гэж байгаа. Тэр хүний. Тэр яахав Цогчэний их унзад гэдэг хамбын дараах хүн байсан. Уншлагынхаа л хамгийн том хүн байсан. Тэрний ах дүүгийн дундаас суварга босгох гэж байгаа юм гэнэ лээ. Хойдох нь 2 овоо тахиж, бүтээл хурдаг юм. Тэр үед тэр суваргаа аравнайж гүйцэтгэх юм гэнэ лээ.

Барэйвүнэд бол би бол одоо ихэвчлэн модон торх үүрдэг хүн байсан юм даа. Дээгүүр уншлагатайд ороогүй. Яахав нэг уншлагаа төгссөн нэртэй болсон. Яахав төгсөөд ганц жил уншсан. Тэгээд сүүлдээ, дороо мартсан даа.

-Цогчэнгийн их гэсгүй нь хэн гэдэг хүн байсан бэ?

Их гэсгүй нь Дүйнхор гэдэг хүн байсан. Урт Гомбожав гэж хүн байсан. 4 гэсгүйтэй шүү дээ. Дамбажунай, Донойн Гомбо гэдэг 4 том гэсгүй байсан.

-Та Барэйвүнгийн их сахиусанд цав манзыг нь барьж байсан юмуу?

Тэнд 6 лам хурдаг байсан. Тэдний цав, манзыг нь барьдаг байсан юм.

-Их сахиус нь дуганыхаа орой дээрээ байдаг байсан гэсэн үү?

Тийм. Яахав тэгээд дээшээ Бага юм барьж байгаа ч гэсэн мөнгөн юунууд хүнд хоёр гурван шатаар дээш гарахад айхтар хүнд байдагсан даа. Нэг талдаа нэг их бурхануудтай байсан. Тэр нь одоо муутуу цаасаар хийсэн юмуу зул барьчихсан байхад гадагш гэрэл өгөхөөргүй шөнө дээд сахиус руугаа цав манжаа аваад ороход айхтар шаггүй хэцүү байдаг байсан. Зууд бол доторх бурханууд нь том том, хүмүүс сууж байгаа юм шиг харагддагсан. Тэр талбай их талбайтай. Одоо үед бол ёстой бүжиг хийж байхаар их талбай байдагсан.

- Барэйвүн хийд маань хуучин ямар сумандаа орж байсан юм бэ? Одоо бол Өмнөдэлгэрт орох юм байна?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Хуучин Хэнтий сумандаа орно. Барэйвүн хийд бол 13 сансар гэж урд уулын ар тал таарч байгаа юм шүү дээ. Зүүн талдаа Баянхангай гэж байгаа. Ар талдаа бол Хойд овоо, Хойд овооноос хойш Энх тэгээд олон том уулнууд бий дээ.

-Өмнөдэлгэр суманд өөр ямар ямар хийдүүд байсан бэ? Өмнөдэлгэр сумын Хүүхэн хутагтын хүрээ гэж байсан байна?

Хүүхэн хутагтын хүрээ чинь энэ баруунтай.

-Мандалын хүрээ гэж байсан уу?

Суварга босгоод байгаа гэнэ лээ. Нэг жаахан хийд байсан байна лээ.

-Хангалын хурал?

Ердөө энэ баруун ам, Зүртийн ам, суварга, нэг жижигхэн хурлын газар байсан юм.

-Эрээтийн хурал гэж ямар хурлыг хэлдэг байсан юм бол оо?

Ай ёстой мэдэхгүй юм байна.

-Эрээт гэж Хүүхэн хутагтын хийдээ хэлээд байгаа юм болов уу?

Итгэлгүй ээ. Хүүхэн хутагт чинь Цагаан суварга гэж Мөрөнд их хүн ирдэг цагаан суварга байсан юм. Одоо бол шинээр баригдаад байгаа. Жилдээ суварганы наадам гэж хоёр ч жил дараалж хийгээд байгаа. Бат-Эрдэнэ аварга энэ тэр ирдэг. Хуучин суурин дээр нь шинээр барьсан юм гэсэн.

-Тэнд Цагаан суварга гэж байсан юмуу?

Хутагтын цагаан суварга гэж байсан юм

-Хурал энэ тэр нь Хутагтын хурлаасаа тусдаа байгаагүй биздээ?

Тухайдаа хурал энэ тэр хурдаг л байсан.

-Тэрийгээ Эрээтийн хурал гэж хэлээд байгаа юм болов уу?

Баруун Жаргалантын суварга гэж байсан юм. Барэйвүнгээсээ зүүн хойно. Тэнд яахав ганц 2 лам хурдаг байсан.

-Хөгний шүтээн гэж хаана байсан байна?

Энэ зүүнтэй гэж байсан гэсэн.

-Саригийн хурал ямар хурал байсан бэ?

Сариг руу нэг хурал байсан байгаа юм. Сарги руу одоо манай Өмнөгийн Талын Булаг бригадын нутаг л даа. Өмнөдэлгэртээ Саригийн хурал орно л доо. Хуучин бригадын хурал байсан. Жижиг л хурал байсан байх. Яригддаг л байсан болохоос биш нэг их нэр хүндгүй байсан.

-Бурхантын шүтээн гэж хаана байсан бэ? Өмнөдэлгэртээ харъяаладдаг байсан уу?

Тийм байх.